

ШИНЭСТ ХК

ШИНЭСТ ХК

Бүртгэлийн дугаар: 2018942
МОД БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР
Хан-Уул дүүрэг, 3-р хороо
Чингисийн өргөн чөлөө, Улаанбаатар, Монгол улс
Утас: 70114414, 88818333
И-мэйл: shinest4414@gmail.com

2024 оны 03-р сарын 20-ны өдөр

Дугаар 24/04


Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ

ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

“Шинэст” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай асуудлаар хэлэлцэж, олонхийн саналыг үндэслэн Тогтоононь:

1. Компанийн 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Хан Уул дүүргийн 3-р хороо Мишээл Групп оффисийн барилга 3н давхарт онлайн болон танхим гэсэн 2 төрлөөр 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 11 цагт зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 1. Компанийн 2023 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайлан
 2. Аудитын хорооны тайлан дүгнэлт
 3. Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын 2023 оны цалин урамшуулал болон зардлын төсөв
 4. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
 5. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэх
 6. Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрлийг ТУЗ-д олгох
 7. ‘Шинэст’ Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон хэлбэрийг өөрчлөх
 8. Компанийн хэлбэрийг өөрчлөх төслийг танилцуулж, Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг шинэчилж батлах
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар мэдээг 2024 оны 03 дугаар сарын 21-ны өдөр, өдөр тутмын 2-оос доошгүй сонин, телевиз болон орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радиогоор мэдээлэх, хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисс /Т. Оюунтүлхүүр/-т даалгасугай.



ШИНЭСТ ХК

ШИНЭСТ ХК

Бүртгэлийн дугаар: 2018942
МОНД БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР
Хан-Уул дүүрэг, 3-р хороо
Чингисийн өргөн чөлөө, Улаанбаатар, Монгол улс
Утас: 70114414, 88818333
И-мэйл: shinest4414@gmail.com

5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар баталсугай. 02 дугаар хавсралтанд заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд Шинэст ХК-ний Мишээл Барилгын Их дэлгүүрийн 2-давхар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Т. Оюунтүлхүүр /-с авч танилцах эрхтэй болохыг дурьдсугай.
7. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах саналын хуудасны загварыг гуравдугаар хавсралтаар баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг харъяалагдах брокер, дилерийн компаниар нь дамжуулан хурал хуралдах өдрөөс ажлын 5-с доошгүй хоногийн өмнө байхаар тогтсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар Э.Болор гишүүдээр Т. Оюунтүлхүүр нарыг тус тус томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Д.Бурмаа, тооллогын комиссын даргаар ТУЗ-н гишүүн Д. Мандах гишүүдээр Т. Оюунтүлхүүр нарыг тус тус томилсугай.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга:/Д.Бурмаа/

